

# “ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон  
санхүүгийн тайлантай холбогдуулан  
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

# “ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 02

Хархорин сум

*Ногдол ашигтай холбогдуулан  
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/2024 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 67,011.1 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2023 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

# “ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 03

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийн бүрэн эрхийн тухай*

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 04 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохгүй байхаар тогтоосугай.
2. Тогтоол гарсантай холбоотойгоор “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх нь цаашид хувьцаа эзэмшигчдийн хурлаас өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд компанийн дүрэмд заасан хугацаанд хүчин төгөлдөр үргэлжэхийг дурдсугай.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ